

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

■ Бүтээн байгуулалтын ажлууд
■ Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
■ Боловсруулах бичиг баримтууд

№	ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ	2016 онд хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлт	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	I улирал			II улирал			III улирал			IV улирал			ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА	ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА
				1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар		
				I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III		
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО																	
Зорилт 5. Байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийг нөхөн сэргээх, зохиистой ашиглахад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, нийт иргэдийн идэвхитэй оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх:																	
48	5.1. Шинэсэн ойн зохион байгуулалт, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.	Судалгааны ажил бүрэн хийлгэж хүлээн авсан байна	1. Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах мэргэжлийн байгууллагуудад санал хүргүүлэх 2. Шалгарсан мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж ажлыг гүйцэтгүүлэх. 3. Заган ой бүхий сумдын ойн менежментийн төлөвлөгөөг хүлээн авах.													Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Сум дундын ойн анги, Сумдын Засаг дарга
49	5.2. Ойжуулалт, Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдад ойжуулалтын гүйцэтгэнэ.	10 га-аас доошгүй талбайд ойжуулалт хийгдсэн байна	1. Хөхморьт, Жаргалан сумдад ойн зурвас байгуулах, Баян-Уул сумд ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд ойн зурвас байгуулах санал хүргүүлэх 2. Төсөл хүлээн авч шалгаруулах 3. Гэрээ байгуулж эхний санхүүжилт олгох 4. Ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих 5. Ногоон хэрэм болон ойн зурвас байгуулах ажлыг хүлээж авах													Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Сумдын ЗДТГ
50	5.3. Аймаг, сумын хэмжээнд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор болзолт уралдаан зарлан дүгнэх	Журам гаргаж, мөрдөж эхэлсэн байна.	1. Ажлын хэсэг гарган болзолт уралдаан, журам боловсруулах 2. Журам батлуулан мөрдөж эхлэх													Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Сум дундын ойн анги, Сумын ЗДТГ
51	5.4. Булаг шандны эхийг хашиж, хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулна.	Булаг шандны тоо 3-аас доошгүй	1. Сумдаас хашиж хамгаалах шаардлагатай бүлгийн судалгаа авна 2. Сумдад техникийн тодорхойлолт хүргүүлж төсөл хүлээн авах 3. Гүйцэтгэчийг шалгаруулж гэрээ байгуулах, санхүүжилт олгох 4. Гүйцэтгэлийн байдалд хяналт тавих 5. Булаг шандны эхийг хашиж хамгаалсан ажлыг акт үйлдэн хүлээн авч орон нутагт нь хариуцуулан гэрээт ажлын эцсийн санхүүжилтийг олгох													Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Сумын ЗДТГ
52	5.5 Төгрөг сумын Далантүрүүний хөвийг сэргээн засварлана.	Хөв сэргээн засварлагдсан байна.	1. Хөвийн зураг төсөвт тодотгол хийх 2. Техникийн тодорхойлолт боловсруулж ХААА-аар тендер зарлуулах 3. Тендерийн баримт бичиг хүлээн авч гүйцэтгэчийг сонгон шалгаруулах 4. Шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан үр дүндчилгээ санхүүжилт олгох 5. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих 6. Ажил хүлээн авах													Байгаль орчин, аялал жуулчлалын газар	ХААА
53	5.6. Химийн хорт болон аюултай бодисын мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, аймгийн хэмжээнд ашиглагдаж буй бодисын хор аюулын тухай лавлах толь бичиг боловсруулна.	Лавлах толь бичиг боловсруулагдсан байна.	1. Ажлын удирдамж боловсруулан төлөвлөгөө гаргах 2. Аймгийн хэмжээнд хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах 3. Химийн хорт болон аюултай бодисын мэдээллийн нэгдсэн сан үүсгэх 4. Хор аюулын тухай лавлах толь бичиг боловсруулан гаргах, хэвлэх													Байгаль орчин, аялал жуулчлалын газар	МХГ, Тагнуулын хэлтэс, ОБГ
54	5.7. Цөлжилтийн иж бүрэн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	Судалгааны ажил хийгдсэн байна.	1. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газарт санал хүргүүлэх, төсвийн тооцоо боловсруулах													Байгаль орчин, аялал жуулчлалын газар	МХГ, Тагнуулын хэлтэс, ОБГ

